

Монголын Үнэт-Цаасны Бирж ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн
27/21 тоот тогтоолын хавсралт



АРИЛЖААНЫ ЖУРАМ

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

ЖУРМЫН АГУУЛГА

Журмын агуулга	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
1.1. Зорилго	4
1.2. Хамрах хүрээ	4
1.3. Хүчин төгөлдөр болох	4
1.4. Нэр томьёо	4
ХОЁР. АРИЛЖААНД ОРОЛЦОГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ	6
2.1. Арилжаанд оролцогчийн төрөл	6
2.2. Бирж, түүний арилжааны үйл ажиллагаа	6
2.3. Брокер, түүний үйл ажиллагаа	6
2.4. Дилер, түүний үйл ажиллагаа	6
2.5. Зах зээл үүсгэгч, түүний үйл ажиллагаа	7
2.6. Андеррайтерийн үйл ажиллагаа	7
2.7. Харилцагч	7
ГУРАВ. АРИЛЖААНЫ ХУВААРЬ	8
3.1. Арилжааны өдрийн хуваарь	8
3.2. Арилжааны цагийн хуваарь	8
ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ДҮРЭМ	9
4.1. Арилжааны дүрэм	9
4.2. Арилжааны үе	9
4.3. Нээлтийн үе	9
4.4. Үндсэн үе	10
4.5. Хаалтын үе	10
4.6. Арилжааны хэлбэр	11
4.7. Тулгалт	11
4.8. Хэлцэл	12
ТАВ. АРИЛЖААНЫ ХЭРЭГСЭЛ	13
5.1. Арилжааны хэрэгсэл	13
5.2. Жишиг үнэ	13
ЗУРГАА. ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ	14
6.1. Захиалгын мэдээллийн сан	14
6.2. Захиалга бүртгэх	14
6.3. Захиалгын төрөл	14
6.4. Захиалгын нөхцөл	14
6.5. Захиалга өөрчлөх, цуцлах	15

ДОЛОО. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ АЖИЛЛАГАА	16
7.1. Анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа зохион байгуулах	16
7.2. Анхдагч зах зээлийн хуваарь	16
7.3. 1 дүгээр үе (Захиалга авах үе)	16
7.4. 2 дугаар үе (Санал болгосон үнээр худалдах үе)	17
7.5. 3 дугаар үе (Тэнцвэрт үнээр худалдах үе)	17
7.6. 4 дүгээр үе (Андеррайтер, Зах зээл үүсгэгч авах үе)	18
7.7. Хуваарилалт	18
7.8. Анхдагч зах зээлийн тайлан мэдээ, Хорооны зөвшөөрөл	18
НАЙМ. АРИЛЖААНЫ МЭДЭЭ, ТАЙЛАН	19
8.1. Арилжааны мэдээ	19
8.2. Арилжааны мэдээ түгээх	19
8.3. Индекс	19
8.4. Арилжааны тайлан	19
ЕС. АРИЛЖААНЫ ХЯНАЛТ	20
9.1. Хяналт хэрэгжүүлэх	20
9.2. Зөрчлийг арилгах	20
9.3. Эрх бүхий этгээдэд мэдэгдэх	20
9.4. Нийтэд зарлах	20
9.5. Арилжаанд оролцогчид хориглох зүйл	20
АРАВ. ШИМТГЭЛ	21
10.1. Арилжааны шимтгэл	21
10.2. Хөнгөлөлт	21
АРВАН НЭГ. БУСАД	22
11.1. Давагдашгүй хүчин зүйл	22
11.2. Маргаан шийдвэрлэх	22

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Зорилго

- (1) Энэ журмын зорилго нь Монголын Үнэт Цаасны Бирж ХК (цаашид “Бирж” гэх)-ийн арилжааны үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, арилжаанд оролцогчдын харилцааг цогцоор зохицуулахад оршино.

1.2. Хамрах хүрээ

- (1) Бирж болон Биржийн гишүүн үнэт цаас компани (цаашид “Гишүүн ҮЦК” гэх), тэдгээрийн харилцагч (хамтад нь “Арилжаанд оролцогч” гэх) энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Хүчин төгөлдөр болох

- (1) Энэ журам, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Биржийн төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) -ийн тогтоолыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батламжилна.
- (2) Хороо өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам нь ТУЗ-ийн тогтоолд заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.4. Нэр томьёо

- (1) Энэхүү журамд заасан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

Арилжаанд оролцогч	Энэ журмын 2.1-т заасныг;
Андеррайтер	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (цаашид “ҮЦЗЗТХ” гэх)-ийн 41.1-д заасныг;
Багцын арилжаа	Биржээс тогтоосон хэмжээнээс өндөр дүнтэй, талуудын урьдчилан тохиролцсон арилжаа
Брокер	ҮЦЗЗТХ-ийн 36.1-д заасныг;
Дилер	ҮЦЗЗТХ-ийн 37.1-д заасныг;
Зах зээл үүсгэгч	Биржтэй зах зээл үүсгэх гэрээ байгуулсан дилерийг;
Харилцагч	Гишүүн ҮЦК-тай “Зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ” (цаашид “Зуучлалын гэрээ” гэх) байгуулсан этгээдийг;
Арилжааны алба	Биржийн бүтэц дэх арилжаа зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгжийг;
Арилжааны үе	Арилжааны хуваарийн ялгаатай нөхцөлөөр тохируулсан хэсгийг;
Арилжааны систем	Арилжаа зохион байгуулах цогц системийг;
Арилжааны хэлбэр	Энэ журмын 4.6.1-т заасныг;
Арилжааны хэрэгсэл	Арилжааны системд бүртгэсэн үнэт цаасны арилжих нөхцөлийг тохируулсан гэрээг;
Арилжааны код	Үнэт цаасны нэрийг арилжааны системд тохируулсан тэмдэглэгээг;
Лот	Үнэт цаасны арилжиж болох (багцлах) доод хэмжээг;

Сондгой лот	Нэг лотоос бага хэмжээтэй үнэт цаасны захиалгыг;
Үнийн хязгаар	Үнэт цаасны үнэ хэлбэлзэж болох хэмжээг;
Авах, зарах үнийн зөрүү (Spread)	Зах зээл үүсгэгчийн авах, зарах захиалгын үнийн зөрүүний дээд хэмжээг;
Хамгийн бага үнийн өөрчлөлт	Үнэт цаасны захиалга оруулах, үнэ бодоход ашиглагдах үнийн өөрчлөлтийн хамгийн бага нэгжийг;
Хамгийн сайн үнэ	Авах хамгийн өндөр, зарах хамгийн бага үнийг;
Аюулгүйн горим (circuit breaker)	Зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн үед автоматаар арилжааг түр зогсоохоор зохицуулсан системийн тохиргоог;
Зах зээл	Үнэт цаасны төрлөөр ангилсан болон анхдагч, хоёрдогч зах зээлийг;
Анхдагч зах зээл	ҮЦЗЗТХ-ийн 4.1.4-т заасныг;
Хоёрдогч зах зээл	ҮЦЗЗТХ-ийн 4.1.5-т заасныг;
Захиалга	Арилжааны системд оруулсан авах, зарах саналыг;
Захиалгын мэдээллийн сан	Арилжааны системд бүртгэгдсэн захиалгуудыг хадгалах санг;
Захиалгын төрөл	Биржээс зөвшөөрсөн захиалгын ангиллыг;
Зах зээлийн захиалга (market order)	Зах зээлийн хамгийн сайн үнээр биелэхийг зөвшөөрсөн захиалгыг;
Зах зээл үүсгэгчийн захиалга (Bid/Ask order)	Зах зээл үүсгэгчийн авах, зарах захиалгыг;
Нөхцөлт захиалга (limit order)	Биелж болох тодорхой нөхцөл бүхий захиалгыг;
Индекс	Биржээс тогтоосон үнэт цаасны дүрэм, салбараар үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлсэн үзүүлэлтийг;
Терминал	Зориулалтын програм хангамж бүхий арилжааны системд холбогдсон гишүүний төхөөрөмжийг;
Харилцагчийн онлайн систем (OMS Order management system)	Харилцагч өөрийн үнэт цаасны мэдээллийг хянах, захиалга оруулах боломжтой Биржийн системтэй шууд холбогдсон системийг;
Эрх бүхий этгээд	Хороо болон хуульд заасан бусад этгээд

(2) Энэхүү журмын нэр томъёонд дурдагдаагүй нэр томъёог ҮЦЗЗТХ, Хороо болон Биржийн холбогдох бусад журамд заасан утгаар ойлгоно.

ХОЁР. АРИЛЖААНД ОРОЛЦОГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ

2.1. Арилжаанд оролцогчийн төрөл

- (1) Арилжаанд оролцогч нь дараах этгээд байна. Үүнд:
 - (i) Брокер;
 - (ii) Дилер;
 - (iii) Андеррайтер;
 - (iv) Зах зээл үүсгэгч;
 - (v) Харилцагч.
- (2) Энэ журмын 2.1.1-ийн (i)-(iv)-д заасан этгээд нь Биржтэй Гишүүнчлэлийн гэрээ байгуулснаар, 2.1.1-ийн (v)-д заасан этгээд Гишүүн ҮЦК-тай Зуучлалын гэрээ байгуулснаар тус тус арилжаанд оролцох эрх үүснэ.

2.2. Бирж, түүний арилжааны үйл ажиллагаа

- (1) Бирж арилжаанд оролцогчдыг ижил тэгш нөхцөлөөр хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэт цаасны арилжааг шударга, ил тод, нээлттэй зохион байгуулна.
- (2) Бирж нь үнэт цаасны арилжаатай холбогдолтой дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:
 - (i) Арилжаанд оролцогчийг тодорхойлж, түүний арилжаанд оролцох эрхийн хэмжээг тус бүрээр нарийвчлан тогтоох, хяналт тавих;
 - (ii) Биржээр арилжихаар зөвшөөрсөн үнэт цаасны арилжааны хуваарь, арга хэлбэрийг тогтоох, арилжаа зохион байгуулах;
 - (iii) Арилжааны тайлан мэдээ, бусад холбогдох мэдээллийг эрх бүхий этгээд болон нийтэд мэдээлэх;
- (3) Бирж арилжааны системийн тохируулгыг хийх, арилжаанд оролцогчийг системд холбох ба системийн ажиллагаанд саатал гарсан тохиолдолд авах арга хэмжээг Арилжааны албаны журамд нарийвчлан тусгана.

2.3. Брокер, түүний үйл ажиллагаа

- (1) Брокер нь Хороо болон Биржээс баталсан журмын хүрээнд Биржийн арилжаанд үнэт цаас худалдах, худалдан авах зуучлалын үйлчилгээг харилцагчид үзүүлнэ.
- (2) Брокер харилцагчийг дараах төрлөөр ангилж харгалзах дансыг нээнэ. Үүнд:
 - (i) Байгууллагын (institutional);
 - (ii) Байгууллагын бус (non-institutional).

2.4. Дилер, түүний үйл ажиллагаа

- (1) Дилер нь ҮЦЗЗТХ-ийн 37 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- (2) Дилерийн эрхтэй Гишүүн ҮЦК нь брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй бол харилцагчийн захиалгыг оруулах цахим эрхийг ашиглан өөрийн хөрөнгөөр арилжаанд оролцох, харилцагчийн захиалгын дарааллыг өөрт ашигтайгаар өөрчлөхийг хориглоно.
- (3) Дилерийн эрхтэй Гишүүн ҮЦК нь зах зээл үүсгэгчээр арилжаанд оролцох хүсэлтийг Биржид хүргүүлж болно.

2.5. Зах зээл үүсгэгч, түүний үйл ажиллагаа

- (1) Дилерийн тусгай зөвшөөрөл бүхий Гишүүн ҮЦК нь гишүүнчлэлийн гэрээнээс гадна зах зээл үүсгэх гэрээг Биржтэй байгуулснаар зах зээл үүсгэгч болно. Зах зээл үүсгэх гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна.
 - (i) Зах зээл үүсгэгчийн төрөл;
 - (ii) Зах зээл үүсгэх үнэт цаас;
 - (iii) Зах зээл үүсгэх хугацаа;
 - (iv) Зах зээл үүсгэгчийн заавал биелүүлэх үүрэг, шаардлага;
 - (v) Зах зээл үүсгэгчид хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх нөхцөл;
 - (vi) Зах зээл үүсгэгчид хариуцлага тооцох.
- (2) Зах зээл үүсгэгчийг зах зээл үүсгэх гэрээний нөхцөлөөс хамааруулан дараах төрлөөр ангилна. Үүнд:
 - (i) Үндсэн зах зээл үүсгэгч (Lead MM);
 - (ii) Туслах зах зээл үүсгэгч (Liquidity Provider);
 - (iii) Биржээс тогтоосон бусад хэлбэр.
- (3) Бирж дараах тохиолдолд тухайн үнэт цаасаар зах зээл үүсгэгч ажиллуулах шийдвэрийг гаргана. Үүнд:
 - (i) Тухайн үнэт цаасны хөрвөх чадвар Арилжааны албаны журамд заасан доод хэмжээнд хүрсэн;
 - (ii) Үнэт цаас гаргагч болон Гишүүн ҮЦК-ийн хүсэлтийг үндэслэн Бирж зах зээл үүсгэх гэрээ байгуулахыг зөвшөөрсөн;

2.6. Андеррайтерийн үйл ажиллагаа

- (1) Андеррайтер нь ҮЦЗЗТХ-ийн 41 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- (2) Хорооны холбогдох журамд заасны дагуу андеррайтер нь анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагааг зохион байгуулах бөгөөд үнэт цаас гаргагч болон андеррайтер тохиролцсон тохиолдолд арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан зохион байгуулж болно.
- (3) Үнэт цаас гаргагчтай тохиролцсоны дагуу андеррайтер нь анхдагч зах зээлд нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг зохион байгуулж байгаа тохиолдолд дараах мэдээллийг Биржид ирүүлнэ. Үүнд:
 - (i) Захиалга хүлээн авах хугацаа;
 - (ii) Зөвшөөрөх захиалгын төрөл;
 - (iii) Захиалга авах хэлбэр;
 - (iv) Захиалгын хэмжээ болон үнийн дээд, доод хязгаар;
 - (v) Хуваарилалт хийх арга;
 - (vi) Хуваарилалтын үр дүнг Биржид ирүүлэх хугацаа.

2.7. Харилцагч

- (1) Харилцагч нь брокертой Зуучлалын гэрээ байгуулснаар Биржийн арилжаанд оролцох эрх нээгдэх ба уг гэрээнд харилцагчийн эрх, үүргийг тодорхойлно.

ГУРАВ. АРИЛЖААНЫ ХУВААРЬ

3.1. Арилжааны өдрийн хуваарь

- (1) Бирж хууль, тогтоомжид заасан нийтээр амрах тэмдэглэлт болон баярын өдрүүдээс бусад ажлын өдрүүдэд арилжаа зохион байгуулна.
- (2) Бирж тухайн жилийн арилжааны өдрийн хуваарийг өмнөх онд багтаан Хороо болон арилжаанд оролцогчид хүргэнэ.
- (3) Бирж арилжааны өдрийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай арилжаанд оролцогчид урьдчилан мэдэгдэнэ.

3.2. Арилжааны цагийн хуваарь

- (1) Бирж арилжааг 09:00 – 16:00 цагийн хооронд зохион байгуулна.
- (2) Бирж арилжааны цагийн хуваарийг арилжааны үе бүрээр тодорхойлж, Хороо болон арилжаанд оролцогчид мэдэгдэнэ. Арилжааны дүрмийг арилжааны үе бүрээр бүрээр тодорхойлно.
- (3) Хороо өөрөөр заагаагүй бол Бирж арилжааны цагийн хуваарийг ажлын таван (5) өдөр хүртэл хугацаанд өөрчлөх бол ажлын нэг (1) өдрийн өмнө, ажлын зургаан (6) өдрөөс дээш хугацаагаар өөрчлөх бол ажлын таван (5) өдрийн өмнө Хороо болон арилжаанд оролцогчдод мэдэгдэнэ.

ДӨРӨВ. АРИЛЖААНЫ ДҮРЭМ

4.1. Арилжааны дүрэм

- (1) Бирж арилжааны дүрмийг арилжааны системд бүртгэнэ.
- (2) Бирж арилжааны дүрмийг үнэт цаасны төрлөөр, үнэт цаас гаргагчийн бизнес, салбар, хөрөнгийн хэмжээ, бусад хэлбэрээр ангилж болно.
- (3) Бирж үнэт цаасны дүрмийн дараах мэдээллийг арилжааны үе бүрээр тодорхойлж, арилжааны системд бүртгэнэ. Үүнд:
 - (i) Үнэт цаасны төрөл;
 - (ii) Цагийн хуваарь;
 - (iii) Арилжааны хэлбэр;
 - (iv) Тулгалт хийх арга;
 - (v) Тулгалт хийх тоо;
 - (vi) Зөвшөөрөх захиалгын төрөл.

4.2. Арилжааны үе

- (1) Арилжааны үе бүрийн цагийн хуваарийг энэхүү журамд нийцүүлэн Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- (2) Арилжаа дараах үеүдтэй байх бөгөөд дараах хуваарийн дагуу явагдана. Үүнд:
 - (i) Нээлтийн үе:
 - i. Захиалга хүлээн авах;
 - ii. Захиалга хуваарилах;
 - iii. Үнэ бодох;
 - (ii) Үндсэн үе;
 - (iii) Хаалтын үе.

4.3. Нээлтийн үе

- (1) Энэ үе нь захиалгаар удирдуулсан арилжааны хэлбэрээр явагдах бөгөөд зах зээл үүсгэгч энэ үед арилжаанд оролцохгүй.
- (2) Нээлтийн үеийн дэд үеүдэд дараах үйл ажиллагаа, үйлдлүүдийг зөвшөөрнө. Үүнд:
 - (i) Захиалга хүлээн авах:
 - i. Өмнөх өдрийн захиалгын сан дахь захиалга шилжиж орно.
 - ii. Шинээр зах зээлийн болон нөхцөлт захиалгыг оруулж болно.
 - iii. Захиалгыг өөрчлөх, засварлах, цуцлах үйлдлийг зөвшөөрнө.
 - (ii) Захиалга хуваарилах:
 - i. Шинээр нөхцөлт захиалга оруулахыг зөвшөөрөхгүй.
 - ii. Зөвхөн шинээр зах зээлийн захиалга оруулж болно.
 - iii. Захиалгыг өөрчлөх, засварлах, цуцлах үйлдлийг зөвшөөрөхгүй.
 - (iii) Үнэ бодох:

- i. Шинээр захиалга оруулахыг зөвшөөрөхгүй.
 - ii. Захиалгыг өөрчлөх, засварлах, цуцлах үйлдлийг зөвшөөрөхгүй.
 - iii. Тэнцвэрт үнийн аргаар захиалгын сан дахь захиалгуудыг үндэслэн нэг удаа тулгалт хийгдэнэ. Үнэ бодогдвол түүгээр нээлтийн үнийг тогтооно.
- (3) Нээлтийн үед үнэ тогтоогүй тохиолдолд арилжааны үндсэн үед биелсэн эхний хэлцлийн үнээр нээлтийн үнэд тооцож болно.
- (4) Нээлтийн үед үнийн хэт савлагаа үүсч, сүүлийн хэлцлийн үнээс энэ журамд заасан хязгаараас давсан тохиолдолд систем аюулгүйн горимд шилжинэ.

4.4. Үндсэн үе

- (1) Нээлтийн үнэ тогтоогүй тохиолдолд зах зээл үүсгэгч нь шууд биелэх (market-to limit) захиалга өгч нээлтийн үнийг тогтооно.
- (2) Үндсэн үед дараах үйлдлийг зөвшөөрнө. Үүнд:
- (i) Арилжааны системд тохируулсан бүх захиалгыг зөвшөөрнө.
 - (ii) Захиалгыг өөрчлөх, засварлах, цуцлах үйлдлийг зөвшөөрнө.
 - (iii) Тухайн өдрийн үнийн хязгаар нь өмнөх өдрийн хаалтын үнээс 15 хувиас хэтрэхгүй байна. Өмнөх өдрийн хаалтын үнэ тогтоогүй бол сүүлийн арилжаа явагдсан өдрийн сүүлийн үнээс тооцно.
- (3) Бирж энэ журамд заасан хязгаарын хүрээнд сүүлийн хэлцлээс тооцох хязгаарлалтыг хийж болно.
- (4) Үндсэн үед үнийн хэт савлагаа үүсч, сүүлийн хэлцлийн үнээс тооцсон хязгаараас давсан тохиолдолд систем аюулгүйн горимд шилжинэ.

4.5. Хаалтын үе

- (1) Хаалтын үе захиалгаар удирдуулсан арилжааны хэлбэрээр энэ үе явагдах бөгөөд зах зээл үүсгэгч энэ үед арилжаанд оролцохгүй.
- (2) Үндсэн үед биелээгүй, хүчинтэй үлдсэн захиалгууд болон хаалтын үед оруулсан захиалгууд тэнцвэрт үнийн аргаар үнэ тогтоно.
- (3) Хаалтын үед дараах үйлдлийг зөвшөөрнө. Үүнд:
- (i) Зах зээлийн, нөхцөлт, кросс болон багцын арилжааны захиалга оруулахыг зөвшөөрнө.
 - (ii) Захиалгыг өөрчлөх, засварлах, цуцлах үйлдлийг зөвшөөрнө.
- (4) Тэнцвэрт үнийн аргаар үнэ тогтоогүй тохиолдолд сүүлчийн хэлцлийн үнийг хаалтын үнэ гэж тооцно.
- (5) Хаалтын үед биелээгүй үлдсэн захиалга дараагийн арилжааны өдрийн нээлтийн захиалга хүлээн авах дэд үе хүртэл хадгалагдан үлдэнэ.
- (6) Хаалтын үе дуусмагц бүх хэлцлийн жагсаалт арилжааны системээс төлбөр тооцооны системд автоматаар шилжинэ.
- (7) Кросс захиалгын биелэх үнэ нь арилжааны үндсэн үед тогтсон өндөр үнээс багагүй байна.

4.6. Арилжааны хэлбэр

- (1) Биржийн арилжааг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
 - (i) Үнээр удирдуулсан (Quote driven);
 - (ii) Захиалгаар удирдуулсан (Order driven);
 - (iii) Хосолсон (Hybrid).
- (2) Үнээр удирдуулсан зах зээлд дор хаяж нэг зах зээл үүсгэгч ажиллах бөгөөд зах зээл үүсгэх эрхгүй арилжаанд оролцогч зөвхөн зах зээл үүсгэгчийн оруулсан авах, зарах үнийн саналыг харна. Энэ тохиолдолд арилжаанд оролцогчийн захиалга зөвхөн зах зээл үүсгэгчийн захиалгатай тулгалт хийгдэнэ.
- (3) Захиалгаар удирдуулсан зах зээлд арилжаанд оролцогч нийт идэвхтэй захиалгыг харах бөгөөд арилжаанд оролцогчийн төрлөөс үл хамааран идэвхтэй захиалгууд хоорондоо тулгалт хийгдэнэ.
- (4) Хосолсон зах зээлд арилжаанд оролцогчид нийт нөхцөлт захиалгыг харах боломжтой бөгөөд бүх захиалга зөвхөн зах зээл үүсгэгчийн захиалгатай тулгалт хийгдэнэ.

4.7. Тулгалт

- (1) Арилжааны системд идэвхтэй захиалгуудаас дараах хэлбэрээр тулгалт хийгдэж хэлцэл бодогдоно. Үүнд:
 - (i) Дуудлага худалдааны арга;
 - (ii) Үргэлжилсэн арилжааны арга;
 - (iii) Тохиролцооны хэлцэл.
- (2) Дуудлага худалдааны аргаар тулгалт хийх үед хэлцлийн үнийг тэнцвэрт үнийн аргаар тогтоосон үнээр, боломжит захиалгуудыг захиалгын төрөл, үнэ, хугацааны эрэмбээр явагдана. Тэнцвэрт үнийн аргаар дараах алгоритмын дагуу үнэ тогтоно. Үүнд:
 - (i) Хамгийн олон ширхэг хувьцаа арилжих үнийг сонгоно;
 - (ii) Эхний шатанд хоёр болон түүнээс дээш ижил үнэ олдсон тохиолдолд биелээгүй үлдэх үнэт цаасны тоо хамгийн бага байх үнийг сонгоно;
 - (iii) Хоёр дахь шатанд хоёр болон түүнээс дээш ижил үнэ олдвол хамгийн сүүлд биелсэн хэлцлийн үнэд ойр үнийг сонгоно;
 - (iv) Гурав дахь шатанд хоёр болон түүнээс дээш арилжиж болох үнэ олдвол эдгээрээс хамгийн өндөр үнийг сонгоно.
- (3) Үргэлжилсэн арилжааны аргаар тулгалт хийх үед арилжаанд оролцогчийн өгсөн захиалга хамгийн сайн нөхцөл бүхий захиалгатай тулгалт хийгдэнэ. Тулгалт хийгдсэн хэлцлийн үнэ нь хугацааны түрүүнд оруулсан захиалгын үнэ байна.
- (4) Бирж харилцан тохиролцсон хоёр болон түүнээс дээш арилжаанд оролцогчийн ирүүлсэн ижил нөхцөл бүхий захиалгыг шууд тулгалт хийж болно. Шууд тулгалт хийх үнэ нь Биржээс зарласан жишиг үнээс хэт зөрүүтэй, үнийн хязгаарлалтыг зөрчсөн бол Бирж тулгалт хийхээс татгалзаж болно.

4.8. Хэлцэл

- (1) Бирж арилжаанд оролцогчийн захиалга эсрэг захиалгуудтай тулгалт хийгдэж хэлцэл үүсэхэд бүртгэнэ.
- (2) Арилжааны алба үүссэн хэлцлийн жагсаалтыг Төлбөр тооцоо эрсдэлийн удирдлагын албанд хуваарийн дагуу хүргүүлнэ.
- (3) Багцын арилжааны хэлцлийн үнийг Биржийн аливаа индекс, арилжааны мэдээнд ашиглагдах үнийн тооцоололд оруулахгүй.
- (4) Захиалга хэсэгчлэн болон бүрэн биелсний дараах үлдсэн захиалга нь захиалгын мэдээллийн санд хадгалагдаж, биелсэн хэсэг нь хэлцлийн жагсаалтад бүртгэгдэнэ.

ТАВ. АРИЛЖААНЫ ХЭРЭГСЭЛ

5.1. Арилжааны хэрэгсэл

- (1) Бирж арилжааны хэрэгслийг арилжааны системд бүртгэх ба бүртгэлд дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:
 - (i) Арилжааны код;
 - (ii) Арилжих нийт хугацаа;
 - (iii) Арилжааны дүрэм;
 - (iv) Эхний үнэ;
 - (v) Лотын хэмжээ;
 - (vi) Хамгийн бага үнийн өөрчлөлт;
 - (vii) Үнийн хязгаарлалт;
 - (viii) Арилжааны системд тохируулсан бусад.
- (2) Биржид бүртгэгдсэн үнэт цаас нь ҮЦЗЗТХ-д заасан төрөлд харгалзах зах зээлд хамаарна.
- (3) Бирж арилжааг нь зогсоосон, бүртгэлээс хассан тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн арилжааны хэрэгслийг системд тэмдэглэн идэвхгүй төлөвт шилжүүлнэ.
- (4) Бирж энэ журмын 5.1.3-т зааснаас гадна арилжих хугацаа дууссан арилжааны хэрэгслийг системд тэмдэглэн хүлээлгийн төлөвт шилжүүлнэ.
- (5) Бирж энэ журмын 5.1.2-т зааснаас гадна анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг тухайн арилжааны хэрэгсэлд хамаарах арилжааны дүрмийн дагуу зохион байгуулна.

5.2. Жишиг үнэ

- (1) Жишиг үнийг үнэт цаасны төрөл, арилжааны идэвхээс хамаарч дараах үнийн аль нэгээр тогтоож болно. Жишиг үнийг Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
 - (i) Сүүлийн 52 долоо хоногийн дундаж үнэ
 - (ii) Сүүлийн 13 долоо хоногийн дундаж үнэ
 - (iii) Сүүлийн 2 долоо хоногийн дундаж үнэ
 - (iv) Сүүлийн 6 сарын арилжааны жигнэсэн дундаж үнэ
 - (v) Сүүлийн 1 сарын арилжааны жигнэсэн дундаж үнэ
 - (vi) Өмнөх өдрийн хаалтын үнэ
 - (vii) Сүүлийн хэлцлийн үнэ

ЗУРГАА. ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

6.1. Захиалгын мэдээллийн сан

- (1) Арилжааны системд бүртгэсэн захиалгыг захиалгын мэдээллийн санд хадгална.
- (2) Арилжаанд оролцогч арилжааны системд холбогдсон терминал ашиглан захиалгын мэдээллийн сангаас өөрийн болон харилцагчийн захиалгын түүхийг авч болно.
- (3) Бирж захиалгын мэдээллийн сангаас эрх бүхий этгээд холбогдох хууль, журмын дагуу шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

6.2. Захиалга бүртгэх

- (1) Арилжаанд оролцогч нь Биржийн арилжааны системд холбогдсон терминал ашиглан захиалга оруулна. Арилжаанд оролцогчийн илгээсэн захиалгыг хугацааны эрэмбээр дугаар олгож, арилжааны системд бүртгэнэ.
- (2) Арилжаанд оролцогч арилжааны системд оруулсан өөрийн захиалгын үр дагавар, эрсдэлийг бүрэн хариуцна.
- (3) Бирж зөвшөөрөгдсөн үнийн хязгаарлалтыг зөрчсөн захиалгыг хүлээлгийн горимоор бүртгэх ба тухайн захиалгын үнэ зөвшөөрөгдсөн хязгаарлалтад орох үед идэвхтэй горимд шилжүүлнэ.
- (4) Бирж энэ журмын 6.2.3-т зааснаас бусад тохиолдолд арилжааны дүрмээр зөвшөөрөөгүй захиалгыг арилжааны системд бүртгэхгүй.

6.3. Захиалгын төрөл

- (1) Арилжаанд оролцогч дараах төрлийн захиалгыг арилжааны системд оруулж болно. Үүнд:
 - (i) Зах зээлийн захиалга (market order);
 - (ii) Нөхцөлт захиалга (limit order);
 - (iii) Зах зээл үүсгэгчийн захиалга (bid/ask order);
- (2) Зах зээлийн захиалгыг захиалгаар удирдуулсан арилжааны үед оруулах бөгөөд захиалгын мэдээллийн санд бүртгэгдсэн идэвхтэй горимтой нийт захиалгын хамгийн сайн үнэ бүхий захиалгатай тулгалт хийгдэнэ.
- (3) Нөхцөлт захиалгыг арилжааны бүх үед оруулах боломжтой бөгөөд тулгалт хийж болох авах дээд, зарах доод үнийг оруулна. Тулгалт хийх төрлөөс хамаарч захиалга өгсөн үнээс сайн үнээр биелэгдэж болно.
- (4) Зах зээл үүсгэгчийн захиалга нь нөхцөлт захиалгатай ижил төрлөөр тулгалт хийгдэх ба захиалгаар удирдуулсан арилжааны үед нөхцөлт захиалгатай, үнээр удирдуулсан арилжааны үед зах зээлийн захиалгатай ижил эрэмбэлэгдэнэ.
- (5) Захиалгаар удирдуулсан арилжааны үед зах зээлийн захиалга, үнээр удирдуулсан арилжааны үед зах зээл үүсгэгчийн захиалга бусад захиалгын төрлөөс эхэнд эрэмбэлэгдэнэ.
- (6) Арилжаанд оролцогчид багцын арилжаа хийх бол Биржид урьдчилан мэдэгдэж, биржийн зөвшөөрлийг үндэслэн захиалга оруулна.

6.4. Захиалгын нөхцөл

- (1) Бирж арилжааны системд захиалгын нэмэлт нөхцөлийг тохируулж болно. Захиалгын нэмэлт нөхцөлийг дараах үзүүлэлтээр тогтооно. Үүнд:
 - (i) Тулгалт хийгдэх хэмжээ;
 - (ii) Идэвхтэй байх хугацаа;
 - (iii) Арилжааны системд зөвшөөрсөн бусад.
- (2) Арилжаанд оролцогч захиалга оруулахдаа арилжааны системд тохируулсан нэмэлт нөхцөлүүдийг сонгоогүй бол Бирж уг захиалгыг арилжааны системд тохируулсан үндсэн нөхцөлөөр бүртгэнэ.

6.5. Захиалга өөрчлөх, цуцлах

- (1) Арилжаанд оролцогч захиалгын мэдээллийн санд бүртгэгдсэн өөрийн оруулсан захиалгын нөхцөлийг өөрчилж болно. Захиалга өөрчлөхөд захиалгын тоо хэмжээг бууруулахаас бусад тохиолдолд өөрчилсөн захиалгыг устгах ба өөрчлөгдсөн захиалга нь шинэ захиалга болж бүртгэгдэнэ.
- (2) Арилжаанд оролцогч захиалгын мэдээллийн санд бүртгэгдсэн идэвхтэй захиалгаа цуцалж болно. Энэ тохиолдолд цуцлагдсан захиалга захиалгын мэдээллийн санд хүлээлгийн горимоор хадгалагдана.
- (3) Бирж арилжаанд оролцогчийн хүсэлт, арилжаа хянагчийн тайлбарыг үндэслэн алдаатай, буруу оруулсан захиалгыг идэвхгүй горимд шилжүүлж болно. Арилжаа хянагчийн тайлбарыг үндэслэн захиалгыг идэвхгүй горимд шилжүүлсэн бол энэ тухай арилжаанд оролцогчид тайлбарлах үүрэгтэй.

ДОЛОО. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ АЖИЛЛАГАА

7.1. Анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа зохион байгуулах

- (1) Холбогдох хууль, журамд заасны дагуу андеррайтерийн компани нь нийтэд санал болгох, захиалга бүрдүүлэх, худалдах, хуваарилах ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, өдрийг тогтооно.
- (2) Бирж нь анхдагч зах зээлд нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг зохион байгуулах тохиолдолд энэ журамд заасан дүрэм, аргачлалын дагуу зохион байгуулна.
- (3) Анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа зохион байгуулах өдрийг 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдэгдэнэ.

7.2. Анхдагч зах зээлийн хуваарь

- (1) Анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа нь дараах үеүдийн дагуу явагдана. Үүнд:
 - (i) Захиалга авах үе;
 - (ii) Санал болгосон үнээр худалдах үе;
 - (iii) Тэнцвэрт үнээр худалдах үе;
 - (iv) Андеррайтерийн баг (синдикатууд) авах үе.

7.3. 1 дүгээр үе (Захиалга авах үе)

- (1) Андеррайтерийн баг тухайн үнэт цаасыг Бүртгэлийн журмын дагуу 50-иас дээш тооны харилцагчид санал болгоно.
- (2) Андеррайтерийн тогтоосон хугацаанд Бүртгэлийн хорооны шийдвэрийг үндэслэн холбогдох журмын дагуу Захиалгын бүртгэлийн аргаар андеррайтерийн баг олон нийтээс захиалгын гэрээний маягтаар анхдагч зах зээлийн захиалгыг авна.
- (3) Биржийн гишүүн компаниудаар дамжин захиалга өгсөн тохиолдолд андеррайтерийн багаар дамжуулан арилжааны системд захиалгыг шивж оруулна.
- (4) Захиалгын гэрээний маягыг Бирж батлах бөгөөд уг захиалгын гэрээнд тусгагдах дансны дугаар, гүйлгээний утга, харилцагчийн дугаарыг Зуучлалын үйлчилгээний гэрээнд зааж өгсөн байна.
- (5) Үнэт цаасыг санал болгосон үнээр худалдахдаа тоо ширхгийг лотоор багцалсан дүнгээр арилжина.
- (6) Андеррайтерийн компани нь үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын дансанд байршуулна.
- (7) Андеррайтерийн багтай урьдчилан тохиролцсон нийт хувьцааны 5%-иас дээших захиалга, тэргүүн ээлжинд авах нөхцөлтэй захиалга болон бусад бүх захиалгыг хүлээн авна.
- (8) Зах зээлийн авах, нөхцөлт, тусгай захиалгын төрлүүд зөвшөөрөгдөнө.

- (9) Захиалгын бүртгэлийн хугацаа дуусахад захиалгын санг хааж, нийт захиалгын биелэлтийг урьдчилсан байдлаар дүгнэн дараагийн үе рүү шилжих шийдвэрийг Биржийн гүйцэтгэх удирдлага тогтооно.

7.4. 2 дугаар үе (Санал болгосон үнээр худалдах үе)

- (1) 1 дүгээр үед өгсөн захиалгын дүнгээс шалтгаалан энэ үеийг эхлүүлнэ. Энэ үе нь нийт үнэт цаасны 5% болон түүнээс дээш хэмжээтэй захиалга өгөхдөө андеррайтертай урьдчилан тохиролцсон болон тохиролцоогүй гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.
- (2) Эхний хэсэг
- (i) Андеррайтертай урьдчилан тохиролцсон нийт хувьцааны 5%-иас дээш хэмжээний захиалга өгсөн этгээдийн захиалга биелэгдэх үе бөгөөд санал болгосон үнээр худалдах аргаар 5 минут үргэлжилнэ.
 - (ii) Захиалгын хэмжээ нийт гаргаж буй үнэт цаасны хэмжээнээс давсан тохиолдолд өндөр үнэтэй, үнэ тэнцсэн тохиолдолд цаг хугацааны хувьд өмнө өгсөн захиалга түрүүлж биелнэ.
 - (iii) Тэргүүн ээлжинд авах нөхцөлтэй захиалга энэ үед биелж болно.
 - (iv) Энэ үед “Монголын Үнэт Цаасны Биржийн гишүүнчлэлийн журам”-д заасан гэрээг андеррайтертай байгуулсан синдикатууд уг гэрээнд заасан хэмжээний үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдаж авах эрхтэй.
- (3) Дараагийн хэсэг
- (i) Санал болгосон үнээр худалдах аргачлалын дагуу явагдах бөгөөд 5 минут үргэлжилнэ.
 - (ii) Андеррайтертай урьдчилан тохиролцоогүй нийт хувьцааны 5%-иас дээш хэмжээний зах зээлийн авах болон тусгай захиалгыг оруулах бөгөөд захиалгын хэмжээ хэтэрсэн тохиолдолд хувь тэнцүүлэх зарчим баримтална.
- (4) Энэ үед нийт үнэт цаас бүрэн зарагдсан тохиолдолд арилжааг хааж, энэхүү журмын 7.7-д заасны дагуу үнэт цаасыг хуваарилна.
- (5) Үнэт цаас бүрэн зарагдаагүй тохиолдолд арилжаа 3 дугаар үе рүү шилжинэ.

7.5. 3 дугаар үе (Тэнцвэрт үнээр худалдах үе)

- (1) 1-р болон 2-р үед өгсөн захиалгын дүн үнэт цаас гаргагчийн татан төвлөрүүлэх хөрөнгөнд хүрэхгүй байгаа тохиолдолд тэнцвэрт үнийн аргаар худалдах энэ үе рүү шилжинэ.
- (2) Энэ үе “тэнцвэрт үнийн аргаар худалдах аргачлал”-ын дагуу явагдана.
- (3) Нийт хувьцааны тоо хэмжээнд хязгаар тавихгүй бөгөөд захиалгын бүх төрлийг зөвшөөрнө.
- (4) Үнэт цаасны хэмжээ нэг лотоос бага хэмжээнд хүрэх хүртэл сондгой захиалгыг бүртгэхгүй.
- (5) Нийт үнэт цаас бүрэн зарагдсан тохиолдолд арилжааг хааж, энэхүү журмын 7.7-д заасны дагуу үнэт цаасыг хуваарилна.

- (6) Энэ үед үнэт цаас бүрэн зарагдаагүй тохиолдолд дараагийн үе рүү шилжинэ.

7.6. 4 дүгээр үе (Андеррайтер, Зах зээл үүсгэгч авах үе)

- (1) 3-р үе дуусахад зарагдаагүй үнэт цаас үлдвэл түүнийг Бүртгэлийн журам болон үнэт цаас гаргах гэрээнд зааснаар андеррайтер болон синдикатууд санал болгосон үнээр худалдан авна.
- (2) Үлдэгдэл үнэт цаасыг худалдан авах хуваарилалт хийхдээ андеррайтер болон синдикатын хооронд байгуулсан гэрээний дагуу тохиролцсон хувь хэмжээ, эсвэл хувь тэнцүүлэх зарчим баримталж болно.
- (3) Энэ үеийн дараа нийт захиалгад алдаа доголдол байгаа эсэхийг арилжаа хөтлөгч хянаж дүгнэсний дараа хуваарилалтыг хийнэ.

7.7. Хуваарилалт

- (1) Анхдагч зах зээлийн захиалгын нийлүүлэлт хэтэрсэн захиалгад хувь тэнцүүлэхтэй холбоотой дараах зарчмыг баримталж болно. Үүнд:
- (i) Андеррайтертай урьдчилан тохиролцсон захиалга биелэх;
 - (ii) Тэргүүн ээлжинд авах;
 - (iii) Биелүүлэх боломжтой доод хэмжээг шаталж нийт дүнгээс хувь тооцох;
 - (iv) Арилжаанд оролцогчдын тоонд харьцуулан хуваарилах;
 - (v) Бусад.

7.8. Анхдагч зах зээлийн тайлан мэдээ, Хорооны зөвшөөрөл

- (1) Хорооны холбогдох журамд заасны дагуу анхдагч зах зээлийн тайлан мэдээг Үнэт цаас гаргагчийн гэрээт андеррайтер Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.
- (2) Хороо анхдагч зах зээлд үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон гэж үзэж, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлсний дагуу Бирж хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх огноог тогтооно.

НАЙМ. АРИЛЖААНЫ МЭДЭЭ, ТАЙЛАН

8.1. Арилжааны мэдээ

- (1) Бирж үнэт цаасны арилжааны үр дүнг арилжаанд оролцогч болон нийтэд зориулан мэдээлнэ. Арилжааны мэдээ нь Биржийн өмч байна.
- (2) Арилжааны үр дүнг бодит цагийн горимд болон арилжааны дараа тогтмол мэдээлнэ. Арилжаанд оролцогчид зориулсан мэдээлэл дараах агуулгын хүрээнд байна. Үүнд:
 - (i) Үнэт цаасны нэр, код, нээлт хаалтын үнэ, дээд доод үнэ, арилжигдсан тоо хэмжээ, жишиг үнэ;
 - (ii) Арилжааны дараах бусад статистик болон тайлант мэдээлэл.
- (3) Нийтэд зориулсан арилжааны мэдээнд арилжаанд оролцогчийн дансны мэдээллийг оруулахгүй ба уг мэдээ нь дараах агуулгын хүрээнд байна. Үүнд:
 - (i) Үнэт цаасны мэдээлэл;
 - (ii) Үнэт цаасны үнийн мэдээлэл;
 - (iii) Үнэт цаасны арилжааны мэдээлэл;
 - (iv) Хууль, журмаар зөвшөөрсөн бусад.

8.2. Арилжааны мэдээ түгээх

- (1) Арилжаанд оролцогчид зориулсан мэдээллийг арилжааны системд холбогдсон Гишүүн ҮЦК-ийн терминал болон Биржээс зөвшөөрсөн бусад хэлбэрээр түгээнэ.
- (2) Нийтэд зориулсан мэдээг Биржийн цахим хуудас болон Биржтэй гэрээ бүхий хэвлэл, мэдээллийн байгууллагаар түгээнэ.

8.3. Индекс

- (1) Бирж нь зах зээлийн өөрчлөлт, нөхцөл байдлыг нийтэд хүргэх зорилгоор индекс тооцож болно. Индексийн төрөл, агуулга, тооцох аргачлалыг Арилжааны албаны журамд заана.

8.4. Арилжааны тайлан

- (1) Бирж нь Хороонд хүргүүлэхээс бусад тохиолдолд нийтэд зориулсан арилжааны мэдээг хугацааны давтамжаар нэгтгэн тайлан болгож нийтэд мэдээлнэ. Арилжааны тайлангийн загвар, хугацааны давтамжийг Арилжааны албаны журамд заана.

ЕС. АРИЛЖААНЫ ХЯНАЛТ

9.1. Хяналт хэрэгжүүлэх

- (1) Бирж нь арилжааг хууль, журмын дагуу зохион байгуулах зорилгоор арилжаа, хяналтын системээр дамжуулан бодит цагийн горимд, арилжаанд оролцогчийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж хяналтыг хэрэгжүүлнэ.
- (2) Хяналт хэрэгжүүлж буй системд тохируулах функц, тайлангийн төрөл, загвар болон арилжаанд оролцогчид хийх хяналт, шалгалтыг зохион байгуулахтай холбоотой нарийвчилсан харилцааг Хяналтын журамд заана.

9.2. Зөрчлийг арилгах

- (1) Бирж хяналт хэрэгжүүлэхэд илрүүлсэн зөрчлийг арилгах зорилгоор зөрчил гаргасан этгээдийн арилжааны эрхийг түдгэлзүүлэх, гишүүнчлэлийн гэрээг цуцлахаас гадна дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - (i) Арилжаа түр зогсоох тухай хүсэлтийг Хороонд хүргүүлэх;
 - (ii) Эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
 - (iii) Нийтэд зарлах.

9.3. Эрх бүхий этгээдэд мэдэгдэх

- (1) Биржийн хяналтаар илрүүлсэн зөрчлийн агуулга, хэлбэрээс хамааран эрх бүхий этгээдэд зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ.

9.4. Нийтэд зарлах

- (1) Хууль, журмаар хориглоогүй бол Бирж хяналт хэрэгжүүлэхэд илрүүлсэн зөрчил болон зөрчилд холбогдох арилжаанд оролцогчийн талаарх мэдээллийг нийтэд зарлана.

9.5. Арилжаанд оролцогчид хориглох зүйл

- (1) Арилжаанд оролцогч Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журам болон Биржийн “Зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх журам”-аар хориглосон зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- (2) Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны холбогдох журам болон Биржийн “Дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын хүрээнд Биржид бүртгэлтэй үнэт цаасны үнэд нөлөөлж болох дотоод мэдээлэл эзэмшигч энэхүү мэдээллийг ашиглан арилжаанд оролцохыг хориглоно.
- (3) Гишүүн ҮЦК нь харилцагчийн дансны мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр ашиглан бусад этгээдэд үнэт цаасыг худалдах, худалдан авахаар санал болгохыг хориглоно.
- (4) Гишүүн ҮЦК, түүний ажилтнуудын үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээ, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцаа нь “Гишүүн, гишүүний ажилтны баримтлах ёс зүйн дүрэм”-ээр зохицуулагдана.

АРАВ. ШИМТГЭЛ

10.1. Арилжааны шимтгэл

- (1) Бирж арилжааны шимтгэлийг Биржийн Шимтгэл, хураамжийн журамд заасны дагуу тооцож, нэхэмжилнэ.
- (2) Бирж арилжааны шимтгэлийн хувь хэмжээг үнэт цаасны төрөл, хэлцлийн авсан, зарсан тал, оролцогч, түүнтэй байгуулсан гэрээгээр ялгаатай тогтоож болно.

10.2. Хөнгөлөлт

- (1) Бирж арилжаанд оролцогчийн төрөл, гүйцэтгэх үүрэг, дансны төрлөөс хамааруулан түүнд тодорхой нөхцөл бүхий хөнгөлөлт үзүүлж болно.
- (2) Бирж хөнгөлөлт үзүүлэх хугацаа, нөхцөл, шаардлагыг холбогдох гэрээнд заасан байна.

АРВАН НЭГ. БУСАД

11.1. Давагдашгүй хүчин зүйл

- (1) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан техникийн саатал, бусад шалтгаанаар арилжаанд оролцогчийн тавиас (50) дээш хувь нь арилжааны системд холбогдох боломжгүй болсон, энэ тухай мэдэгдэл ирүүлсэн тохиолдолд Бирж арилжааг зогсоох, эсвэл арилжааг гар ажиллагаанд шилжүүлж болно.
- (2) Гар ажиллагааны үед арилжаа зохион байгуулах тухай нарийвчилсан зохицуулалтыг Арилжааны албаны журамд заасан байна.

11.2. Маргаан шийдвэрлэх

- (1) Арилжаанд оролцогчдын хооронд үүссэн аливаа маргааныг холбогдох гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.